Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЖАМСРАНЖАВ СОЛОНГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт ) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Нийгмийн салбарын талаарх хууль тогтоомж, бодлого шийдвэр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах, арга зүйгээр хангах, тайлагнах** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1.** Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа Ахмад настны тухай хууль, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Төрөөс олгох санхүүгийн дэмжлэг, тэтгэлэгийн талаар авах зарим арга хэмжээний тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмын талаар иргэдэд мэдээлэл өгөх | Сургалт мэдээлэлд хамрагдсан иргэдийн тоо | - | 60 | Ахмад настны тухай хууль -30 ахмад, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийг 83, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн талаар 15 байгууллагын 25 иргэнд, төрөөс олгох санхүүгийн дэмжлэг тэтгэлэгийн талаар авах зарим арга хэмжээний тухай хууль, Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмын талаар 2 оюутанд санхүүгийн дэмжлэг олгосон.<br>Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.12 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн хохирол хэрэгцээний | 01-01<br>06-05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үнэлгээ хийх журам"-ыг гэр шатсан 7 иргэн нийт 135 иргэнд дээрхи хуулиудыг танилцууллаа. | | |
| 2 | **Арга хэмжээ 1.2.** Сумын ахмадын хороо, эмэгтэйчүүдийн зөвлөл, нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлтэй холбоотой тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж ажиллах | Тайлан мэдээний тоо | | 3 | Сумын ахмадын хороотой 2025 онд хамтран ажиллах гэрээ байгуулан 2025 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br>Эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран 2025 онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан Засаг даргаар баталгаажуулан хэрэгжилтийг хангаж хангаж ажиллаж байна. Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хуралдуулж, 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг гаргаж, батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нийгмийн салбар хорооны хуралдаанаар 2024 онд Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлөөс хийсэн ажлын тайланг танилцуулж дүгнүүлсэн. | 01-01<br>06-05 | 100 |
| 3 | **Арга хэмжээ 1.3.** Салбарын үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж тайлан мэдээг гаргаж ажиллах | Тайлан мэдээний тоо | | 4 | "Нийтийн мэдээллийн ил тод байдал", үндэсний хөтөлбөр, "Хүмүүнлэг"-ийн дэд хөтөлбөр, "Нээлттэй Өвөрхангай" дэд хөтөлбөрүүдийн 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулж, хэрэгжилтийг хангаж хяналтандаа авч ажиллаж байна. "Орон нутгийн өсвөр | 01-01<br>06-05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтерпренершип боловсрол олгох" төслийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэг гүйцэтгэж байна. | | |
| | **Дэд арга хэмжээ 1.3.1** Сумын жендэрийн дэд салбар хороо байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулан, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах | Дэд зөвлөл Арга хэмжээний тоо | | 2 | "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний биелэлтийг хангах ажлын хүрээнд 2025 онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. "Харилцан хүндэтгэе" аяны хүрээнд сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулан 12 байгууллагын 25 албан хаагч оролцлоо. Хархорин фэйсбүүк хуудсаар "Харилцан хүндэтгэе" аяны уриа үгс, лого гэх мэт сурталчилгааны 4 төрлийн зурагт хуудас бэлтгэн байршуулсан.<br>Жендэрийн үндэсний хорооноос Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг "Технологи ашиглан үйлдэгдэж буй Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд нэгдье" уриатайгаар зохион байгуулж байна. Тус аяны хүрээнд Засаг даргын Тамгын Газрын эмэгтэйчүүдэд "Өөрийгөө хайрлахуй" сургалтыг Орхон сургуулийн эцэг эх багшийн холбоо ТББ-тай хамтран зохион байгуулав. | 01-01<br>04-01 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Дэд арга хэмжээ 1.3.2** "Хүмүүнлэг" дэд хөтөлбөрийн хүрээнд Иргэдийн өөрийн болон бусдын амь насыг гамшиг ослоос хамгаалах, сэргийлэх, нөхөн сэргээх, гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ чадавхийг нэмэгдүүлэх, зохих мэдлэг дадлага олгох замаар эрүүл мэнд аюулгүй амьдралыг эрхэмлэх, хандлагыг нэмэгдүүлэх, олон улсын улаан загалмайн хороотой хамтран ажиллах, хамтын ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх, сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөө болосвруулах тайлан мэдээг нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэнэ. | Тайлан мэдээний тоо | | 1 | Хүмүүнлэгийн дэд хөтөлбөрийн 2025 онд 5 зорилтын хүрээнд 19 ажил хийх ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг хангаг ажиллаж байна. "Хүмүүнлэг" дэд хөтөлбөрийн 2024 онд хийсэн ажлын тайланг бэлтгэж, Иргэдийн Төлөөлөгчдийн нийгмийн бодлогын салбар зөвлөлд танилцуулан дүгнүүлсэн.<br>2025 оны Хархорин сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гарган батлуулж, тодотгол, судалгаа мэдээллийг шинэчлэн боловсруулсан.<br>Үерийн эрсдэлтэй газар суурьшсан айл өрхийн 8 багийн 111 өрхийн судалгааг гарган нэгтгэсэн.<br>Улсын Онцгой комиссын албан даалгавар "Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай", Монгол Улсын Байгаль, Орчин, Уур амьсгалын өөрчлөлтийн сайдын тушаал "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай" удирдамж, төлөвлөгөөний дагуу хяналтанд авч биелэлтийг цаг тухай бүр гарган хэрэгжүүлж ажиллаж байна. Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж шинэчлэн Засаг даргын захирамжаар баталгаажуулж, сайн | 01-01<br>06-05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дурын хэсгийн гишүүдийг Өвөрхангай аймгийн Онцгой байдлын Газраас зохион байгуулсан сургалтанд 11 иргэнийг хамруулсан. Сумын Онцгой Комисс, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж, Засаг даргын захирамжаар баталгаажуулав.<br>Онцгой комиссын хурлыг 3 удаа хуралдуулж, шийдвэр гаргасан.<br>“Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”, “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах” нэгдсэн дадлага сургуулийг 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 16 цагт зохион байгуулан ажиллав.<br>Байгалийн гамшигт өртсөн 5 өрхийн өргөдлийг хүлээн авч орон гэр нь нурсан, галд өртсөн өрхүүдийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, эд хөрөнгийн үнэлгээг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж 5 өрхийг Онцгой байдлын хэлтсийн байцаагчийн дүгнэлт гаргуулан халамжийн сангаас тус бүр 1.2 сая төгрөг нийт 6 сая төгрөгийн тэтгэмж олгох нөхцлийг бүрдүүлсэн.<br>Дайлчилгааны бэлэн байдлыг хангах зорилгоор авто техник хэрэгслийн судалгааг гарган | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэгтгэж, статистик хүснэгтийн дагуу мэдээллийн сан бүрдүүлэв. | | |
| 4 | **Дэд арга хэмжээ 1.3.3** Хүний эрхийг хангах Үндэсний хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх журам"-ын 2.3-д сум, баг, хорооны Засаг дарга хүний эрхийн төлөв байдлын тайланг аймаг, нийслэлийн Засаг даргад тухайн жилийн 12 дугаар сарын 05-ны дотор хүргүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж, 2025 оны төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, тайлагнах | Тайлан мэдээний тоо | | 1 | Орон нутагт хүний эрх хангах дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, Засгийн газрын 2023 оны 231 дүгээр "Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний орон нутагт хамаарах заалтын төлөвлөгөөний 2025 оны биелэлт, Хүний эрхийн хувийн хэрэг (Орон нутгийн) статистик тоон мэдээллүүдийг тус тус гарган Өвөрхангай аймгийн Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлэв. | 11 сард | 100 |
| 5 | **Дэд арга хэмжээ 1.3.4** Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6-г хэрэгжүүлж, (Хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг төрийн байгууллагууд дотоод журамд тусгаж, хэрэгжүүлэх) уг хуулийг судалж, төрийн албан хаагч, иргэдэд сургалт мэдээлэл зохион байгуулж, түгээн дэлгэрүүлэх | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | | 310 | Хүний эрхэд суурилсан хандлага сургалт хэлэлцүүлгийг хүний эрхийн комиссын Өвөрхангай аймгийн референт Туултай хамтран зохион байгуулсан. Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, доктор, дэд профессор Б.Энхболдоор ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 05 дугаар сарын 20-21-ны өдрүүдэд ажилласан. Төрийн албан хаагч, иргэдэд "Хүний эрхэд суурилсан хандлага" сэдэвт сургалт зохион байгуулж, 310 төрийн албан хаагч, иргэд хамрагдлаа.<br>"Иргэдээ сонсъё" нээлттэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгууллаа. | 05-20<br>05-21 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | **Дэд арга хэмжээ 1.3.5** Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг нээлттэй мэдээлэх арга хэмжээг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | | 510 | Хууль хяналтын байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт хийлээ. Өвөрхангай аймгийн Хархорин суманд зохион байгуулсан “Хүний эрхийн төлөө хамтдаа” нээлттэй өдөр арга хэмжээний хүрээнд Сум дундын Шүүхийн Тамгын газар, Прокурорын газар, Цагдаагийн хэлтэс, ШШГХ-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн удирдлага, Нэгдсэн эмнэлэг, Ерөнхий боловсролын Орхон сургууль зэрэг албан байгууллагуудын албан хаагчидтай ХЭҮК-ын гишүүн Б.Энхболдоор ахлуулсан ажлын хэсэг уулзалт зохион байгууллаа.<br>Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэх зэрэг хөдөлмөр эрхлэхэд хүний эрх хэрхэн хангагдаж байгаа талаар хяналт шалгалтыг явуулж зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Монгол Улс, Франц Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жил, Өвөрхангай аймаг, Франц Улсын Аллиер мужтай найрсаг харилцаа тогтоосны 25 жилийн ойн арга хэмжээний ажлын хүрээнд Франц Улсын Аллиер мужаас ирсэн сэтгэл судлаач, секслогоч Алинэ Дупик "Ажлын байран дээрх халшрах хам шинж" буюу "BURN OUT" сэдвээр төрийн албан хаагч нарт сургалт зохион байгууллаа. Сургалтад Засаг даргын Тамгын газар, Сум дундын Прокурорын газар, Шүүхийн Тамгын газар, Цагдаагийн | 05-20<br>05-21 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс, 423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Онцгой байдлын хэлтэс, шүүхийн шинжилгээний албаны алба хаагчид, Ерөнхий боловсролын 4 сургууль, 5 цэцэрлэгийн багш, ажилчид нийт 200 гаруй төрийн албан хаагчид хамрагдлаа.<br>Либраль эмэгтэйчүүдийн оюуны сангийн Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлтэй хамтран "Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сургалтыг төрийн байгууллагын удирдах албан хаагчид болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад зохион байгууллаа.<br>Сургалтанд 60 гаруй албан хаагч, 210 сурагч хамрагдлаа. | | |
| 7 | **Дэд арга хэмжээ 1.3.6** Хүний эрхийн Олон улсын тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх чиглэлээр төлөвлөгөө (жилийн турш хэрэгжүүлэх) батлан төрийн албан хаагчид, олон нийтийн хүний эрхийн боловсрол, мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, сургалт нөлөөллийг арга хэмжээ зохион байгуулах | Сургалт нөлөөллийн арга хэмжээний тоо | - | 80 | Төрийн албан хаагч, иргэдэд "Хүний эрхэд суурилсан хандлага" сэдэвт сургалт зохион байгуулж, 310 төрийн албан хаагч, иргэд хамрагдлаа.<br>Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, монгол цэргийн өдрийг тохиолдуулан жендерийн хорооноос жил бүр зохион байгуулдаг "Харилцан хүндэтгэе" 1 сарын аяныг "Хайраа хайрлъя, хандлагаа өөрчилье, хамтдаа үлгэрлье" уриатайгаар зохион байгуулав.<br>Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн "Хүүхэд хайр ирээдүй" сэдэвтэй хүүхдийн баярын арга хэмжээг | 05-20<br>05-21<br>03-08<br>06-01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулж нийт 3500 гаруй хүүхэд хамрагдсан.<br>Олон улсын Ахмад настны эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн ахмадын хороотой хамтран "Ахмадын баяр 2025" урлаг соёлын үйл ажиллагаа зохион байгууллаа. | 10-01 | |
| | **Зорилт 2. Эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт, хүн ам, жендерийн тэгш байдлын асуудлаар хөтөлбөр, төсөл боловсруулах, төлөвлөх, зохицуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангах, тайлагнах** | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 2.1** Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, сумын ахмадын хороотой хамтран ажиллах гэрээ байгуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах | Хамрагдсан ахмад настан | - | 1 | Сумын ахмадын хороотой 2025 онд хамтран ажиллах гэрээ байгуулан 2025 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна. | 01-01<br>12 сар | 100 |
| 2 | **Арга хэмжээ 2.2** Ахмадын сан, Ахмадын тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн, ахмадын насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлж, идэвхтэй амьдралын хэв маягийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | Ахмадын сантай болсон байгууллагын тоо<br>Ахмад настанд чиглэсэн сургалт, арга хэмжээний тоо | - | 1 | 2025 онд төрийн байгууллагуудыг хамруулан ахмадын сан байгуулах, ахмад настны нийгмийн баталгааг сайжруулах талаар 15 байгууллагад мэдээлэл хүргүүлж, үүний үр дүнд 2 байгууллага ахмадын сан байгуулан нийт 24 сая төгрөгийг төвлөрүүлжээ.<br>Насан туршийн боловсролын арга зүйчтэй хамтран дэлхийн хуримтлалын өдрийг тохиолдуулан "Хуримтлуулъя, хадгалъя" сэдэвт сургалтыг зохион байгуулж 15 ахмад настан хамрагдсан байна.<br>Франц улсын аллиер мужийн Ерөнхий эмч Жан Клод Дэспрэ, нийгмийн ажилтан Нэлли Дэлма нар "Ахмад настны эрүүл мэнд ба ахмадын онцлог" сэдвээр ахмад | 01-01<br>03-15 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | настнуудын дунд сургалт зохион байгууллаа.<br>90 ба түүнээс дээш настай ахмадуудын судалгааг гарган хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулав. 100 буюу түүнээс дээш настай 2 ахмад, 90 ба түүнээс дээш настай 27 ахмад нийт 29 ахмадад Ерөнхийлөгчийн болон Өвөрхангай аймгийн Засаг даргын гарын бэлгийг гардуулан өгсөн. Засаг даргын Тамгын газрын 36 ахмад настанд сар шинийн хүндэтгэл үзүүлэх ёслолын үйл ажиллагаа зохион байгуулсан.<br>Засаг даргын Тамгын Газраас тэтгэвэртээ гарсан 20 ахмад настанг Хужирт сумын Сэмжид амралтын газар амраав. | | |
| 3 | **Арга хэмжээ 2.3** "Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох" төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | Хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн тоогоор | - | 3 | "Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтерпренершип боловсрол олгох" төслийг хэрэгжүүлэх ажлыг Японы хүүхдийг ивээх сантай хамтран зохион байгуулав. Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар энтерпернершип боловсрол олгох Питч 8 үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж төслийн сумын зөвлөлийн хурлаар 4 төсөл орсноос Гүнзгий сургуулийн "Little Influencer" төсөл шалгарч японы хүүхдийг ивээх сангаас 2,6 сая | 01-01<br>03 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгрөгийн санхүүжилт авсан. Б.Мягмарсүрэн 1,5 сая төгрөг, "Б.Э.Х.ХЗХоршоо" 1,3 сая төгрөг, Гүнзгий сургуулиас 400,0 төгрөг, Х.Мөнхзул 250,0 төгрөг нийт 3,450,000 төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлж ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн "Поннийгийн найзууд", Гүнзгий сургуулийн төслүүдийг санхүүжүүлэв.<br>Өсвөр үеийнхний хувь хүний хөгжлийг дэмжих, бизнесийн санаачлага болон энтрепренершип боловсрол олгох зорилгоор 2025-2026 оны хичээлийн жилд нийт 88 сурагч, 2 багшийг тус хөтөлбөрийн сургалтад хамруулж, мэдлэг, ур чадварыг нь нэмэгдүүллээ. | | |
| 4 | **Арга хэмжээ 2.4** Эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалт, арга хэмжээг зохион байгуулж, хөгжих, оролцох боломжийг хангана. | Эмэгтэйчүүдэд чиглэсэн сургалт, арга хэмжээний тоо | | 3 | Эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран 2025 онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан Засаг даргаар баталгаажуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. "Өөрийгөө хайрлахуй" сэдэвт сургалт зохион байгуулж 25 ээжийг хамрууллаа. "Эхийн алдар" 1, 2 дугаар одонгоор шагнагдах 83 эхчүүдийн материалыг хүлээн авч Өвөрхангай аймгийн нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэв. "Ээжүүдээ одонгоо зүүцгээ" эхийн алдар одон гардуулах ёслолын үйл ажиллагааг зохион байгуулан | 01-01<br>06-01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллав. Эхийн алдар одонгоор шагнагдсан эхчүүдийн ар гэрт холбоо барьж үр хүүхдүүдээс ведио бичлэг, алдарт эхийн одонтой 8 эхээс "Эхийн алдар" одон гардуулах баярын мэндчилгээний бичлэг ведио хийлгэсэн. | | |
| | **Зорилт 3. Суманд үйл ажиллагаа явуулж буй нийгмийн салбар байгууллагуудын ажлыг уялдуулах, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах** | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 3.1** Сумын Ахмадын хороо, эмэгтэйчүүдийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, ахмад, эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 2 | Ахмадын хорооноос 2025 оны сумын аварга тамирчдыг шалгаруулах 5 төрлийн спорт тэмцээн зохион байгуулж, 250 гаруй ахмад настан хамрагдлаа. "Хархорин Марафон-2025" гүйлтийн тэмцээнд 80 гаруй ахмад настан амжилттай оролцсон.<br>"Ахмадын баяр 2025" арга хэмжээ зохион байгуулж 250 гаруй ахмад настан оролцлоо. Тус өдөрлөгийн арга хэмжээнд зориулж 700,000 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулав.<br>Өвөрхангай аймгийн Ахмадын хорооноос хоёр өдрийн турш зохион байгуулсан "Ахмадын урлаг спортын бага наадам-2025" арга хэмжээнд 250 гаруй ахмад настан амжилттай оролцож II байр эзэлсэн.<br>Урлаг спортын бага наадамд оролцох зардалд 660,330 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулсан байна.<br>Ахмадуудад "Ахмад настны тухай" хууль, "Нийгмийн халамжийн тухай" хуулиудын талаар сургалт, | 01-01<br>10-01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Хувь хүний санхүүгийн төлөвлөлт" сэдвүүдээр мэдээлэл хийж 50 гаруй ахмад настан хамрагдлаа. Эмэгтэйчүүдийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллах талаар хамтран ярилцаж байна. Эмэгтэйчүүд рүү чиглэсэн 1 арга хэмжээ зохион байгуулан ажиллав. | | |
| | **Арга хэмжээ 3.2** Сумын нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж, иргэдэд эрүүл мэндийн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br>Сургалтанд хамрагдсан иргэдийн тоо | | 2 | Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилж, ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хүний папиллома верусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах ажлыг эрчимжүүлэх тухай Хархорин суманд ажиллах хугацаанд "Дархлаажуулалтыг хүн бүрт" уриан дор зохион байгуулагдаж буй дэлхийн 7 хоног, дархлаажуулалтын ач холбогдлыг сурталчилсан өдөрлөгийг сумын Засаг даргын Тамгын Газар, Энэрэл Хархорин өрхийн эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран зохион байгууллаа. Өдөрлөг болон сургалтад Хархоринд сумын удирдлагын төлөөлөл, багш ажилтан, сурагчид, эцэг эхчүүд зэрэг 400 гаруй хүн хамрагдаж, 204 хүүхдийг дархлаажуулалтад хамрууллаа. | 01-01<br>06-05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Франц улсын Аллиер мужийн АПАУ нийгэмлэгийн эмч, ажилчид ажиллаж ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн тусгай хэрэгцээт хүүхдэд, Нэгдсэн эмнэлэгтэй хамтарч ажиллав.<br>АНУ-д төвтэй Холт Интернэшнл ТББ-ын Хүүхдийн Хоол Тэжээлийн Хөтөлбөр (ХХТХ)-ийн хамт олонтой хамтарч хоол тэжээлийн талаар сургалтыг 06 сарын 06-ны өдөр зохион байгуулж 23 иргэн хамрагдлаа.<br>АНУ-д төвтэй "Холт Интернэшнл" төрийн бус байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газраас хүүхдийн хоол тэжээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд "Энэрэл Хархорин" өрхийн эрүүл мэндийн төвд хүүхдийн өсөлт болон цус багадалтын хяналтын багаж, зогсдог жин хэмжигч, дижитал дэлгэцтэй цэнэглэгч, хемокю аппаратыг оношлуурын хамт, 6 сая төгрөгийн нярайн болон бага насны хүүхдийн өндөр, жинг хэмжих зориулалттай модон хэмжигч хандивлалаа.<br>Цэргийн насны залуучуудад "Эрүүл мэндийн сургалт зохион байгуулж 20 залуу оролцсон.<br>Ажилчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор эрүүл мэндийн ядаргаа тайлдаг 640, 000 төгрөгийн үнэтэй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2 ширхэг массажны ор авч амралтын өрөөнд байршуулав. | | |
| | **Зорилт 4. Нийгмийн зорилтот бүлгүүд, хүн ам, өрхийн суурь судалгааг нарийвчлан гаргаж, тэдгээрт чиглэсэн үйл ажиллагааг орон нутгийн бодлого боловсруулахад тусгуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах** | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 4.1** Нийгмийн зорилтот бүлгүүд, хүн ам, өрхийн суурь судалгааг нарийвчлан гаргаж, тэдгээрт чиглэсэн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах, хэрэгжилтийг хангах тайлагнах | Зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээний тоо | | 2 | Хархорин сумын нийт хүн амын судалгаа, Ахмад настан, Боловсрол, Эрүүл мэнд, Малын тоо, Эдийн засаг, газар тариалан гэх мэт статистик тоон үзүүлэлтүүдийг гарган нэгтгэсэн. | 01-01 06-05 | 100 |
| 2 | **Арга хэмжээ 4.2** kharkhorin.ov.gov.mn вэб сайт хөтлөлтийг сайжруулах, мэдээллийг тухай бүр оруулж, нийтийн зар мэдээний самбаруудад байршуулах | Байршуулсан мэдээний тоо | | 80 | Нийтийн зар мэдээний самбарт 155 төрлийн мэдээллийг байршуулан олон нийтэд мэдээлэл хүргэсэн. kharkhorin.ov.gov.mn вэб сайтад эрхэм зорилго, алсын хараа, сумын товч танилцуулга, бүтэц зохион байгуулалт, Засаг даргын захирамж 89, Засаг даргын 2024-2028 оны мөрийн хөтөлбөр, мэдээлэл хэсэгт 25 мэдээлэл хууль эрх зүй хэсэгт Ligal.info сайтанд холболт хийсэн. | 01-01 06-05 | 70 |
| 3 | **Арга хэмжээ 4.3** Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 208 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, төрийн нэгдсэн цахим хуудас www.gov.mn-д мэдээллээ байршуулж ажиллах | Байршуулсан мэдээний тоо | | 40 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 208 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж төрийн нэгдсэн цахим хуудас www.gov.mn 250 мэдээлэл оруулж, мэдээллээ ил тод байршуулан ажиллалаа. Төрийн байгууллагуудын үйлчилгээний мэдээллийг нэгтгэж Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар хүргэсэн. | 01-01 06-05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | **Арга хэмжээ 4.4** Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 5 төрлийн 68 мэдээллийг сумын байгууллага бүр олон нийтэд ил тод мэдээлэх, мөн shilen.gov.mn системд Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын дагуу байршуулж, үнэлүүлэх | Байршуулсан мэдээний тоо | | 60 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 5 төрлийн 155 мэдээллийг сумын байгууллага бүр олон нийтэд ил тод мэдээлэх, мөн shilen.gov.mn системд Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан. Мэдээллийн ил тод байдалтай холбоотойгоор shil.gov.mn сайтад сумын мэдээллийн талаарх тайланг оруулж программд шивсэн. "ХАМТДАА ШИЙДЬЕ" үйл ажиллагааны хүрээнд Хархорин сумын иргэдтэй уулзалт, арга хэмжээнд оролцож, төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллаж, Эрдэнэзуу музей, Соёлын төв, хүүхдийн 5 дугаар цэцэрлэг, Прокурорын газар, Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ны Хархорин сум дахь салбар байгууллагуудад shilen.gov.mn сайтын бүртгэл үүсгэж, мэдээлэл өгсөн. | 01-01<br>03-20 | 90 |
| | **Зорилт 5. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах** | | | | | | |
| 6 | **Арга хэмжээ 5.1** ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх; | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | | 80-100% | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, төлөвлөгөөний биелэлтийг гарган ажиллаж байна. | 01-06<br>12-20 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | **Хүрсэн түвшин (биелэлт)** | Эхэлсэн дууссан хугацаа | **Биелэлтийн хувь** |
| | 1 | 2 | 4 | 5 | 6 | 7 | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Албан тушаал, мэргэжил, арга зүйн чиглэлийн сургалт, семинарт оролцох, практик туршлагаа нэмэгдүүлэх | Хамрагдсан сургалт арга хэмжээний тоо | | | Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газрын нийгмийн ажилтан зохион байгуулсан Хамтарсан багийн чадавхижуулах сургалтанд хамрагдсан.<br>“Хүний эрхэд суурилсан хандлага” уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон.<br>“Ажлын байрны дарамт, халшрах хам шинж” сургалтанд хамрагдсан. "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалтанд хамрагдсан.<br>“Эмнэлэг хүртэлх гэмтэгсдийг аврах тусламж” сэдэвт богино хугацааны сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан. | 01 сар | 100 |
| 2. | **Арга хэмжээ 1.2.** Төрийн албаны цахим хуудсаны бодлогын инноваци цэсэнд байршуулсан вебинар сургалт, мэдээллийг бие даан судлах | Бие даан судалсан сургалт, мэдээллийн тоо | | | “7:4:10” цахим вэбинар сургалтанд Төрийн албан хаагчийн ёс зүй сургалтанд хамрагдсан.<br>“Цахим засаглал, хиймэл оюун ухаан” сэдэвт цахим сургалтанд хамрагдсан.<br>Удирдлагын академийн цахим сургалтад хамрагдаж Microsoft 365 программын хэрэглээ сэдэвт гэрчилгээ авсан.<br>Удирдлагын академийн Монгол бичгийн анхан, дунд шатны цахим | 03 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.<br>Удирдлагын академийн цахим сургалт "Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт: Байгууллагын хүрээнд оролцоонд суурилсан жендерийн аудит хийх" 2-р түвшний сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан. | | |

**Гурав. Нэмэлт үүрэг, даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | ҮҮрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | **Хүрсэн түвшин (биелэлт)** | Эхэлсэн дууссан хугацаа | **Биелэлтийн хувь** |
| | 1 | 2 | 4 | 5 | 6 | 7 | |
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. | | | | Цэргийн шинэчилсэн бүртгэлийн ажлын хэсэгт орж ажиллан сумын 2025 оны цэрэгт бүртгэлтэй 18-60 насны эмэгтэйчүүдийн тоон мэдээллийн бүртгэлийн нэгдсэн мэдээ, дайчилгааны бэлтгэл нөөцийн байршлын тоон бүртгэлийн нэгдсэн мэдээ, баг орон нутаг дэвсгэрт бүртгэлтэй авто техник, хэрэгсэл, өөрөө явагч механизмын судалгаа, агт морь, хувийн өмчийн ердийн хөсөг, түүний тоон хэрэгслийн мэдээ зэрэг тоон мэдээллүүдийг нэгтгэсэн.<br>2025 оны 1 дүгээр цэрэг татлагын ажилд байр танхим засах, бэлтгэл хангах ажлыг хийж гүйцэтгэсэн. Ээлжит цэрэг татлагаар 7 цэрэг тэнцэж тэдгээр залуучуудын шинжилгээний бичиг баримт, бусад | 04-30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох бичиг баримтуудыг цэгцэлж бүрдүүлэх материалуудыг бүртгэлжүүлэн хүлээлгэн өгсөн. | | |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. | | | | Монгол Улс, Франц Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жил, Өвөрхангай аймаг, Франц Улсын Аллиер мужтай найрсаг харилцаа тогтоосны 25 жилийн ойн арга хэмжээг 2025 оны 04, 05 дугаар сарууддад Өвөрхангай аймагт тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Франц Улсын Аллиер мужаас 7 хүний бүрэлдэхүүнтэй баг манай суманд ажиллахаар ирлээ.<br>2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 5 дугаар сарын 03-ны хооронд тусгай хэрэгцээт хүүхдүүдэд үзлэг, зөвлөгөө, сэтгэл зүйчийн зөвлөгөө, эцэг, эх, асран хамгаалч нарт хөдөлгөөн заслын сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллана. | 04-05 сар | 100 |
| 3 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. | | | | Цэгцлэгч MOOD төслийн багийнхантай хамтран ерөнхий боловсролын 4 сургуулийн 16 сурагчдыг оролцуулан "Бүсний мангас" тэмцээн зохион байгуулав. Тус тэмцээн нь хүүхэд залуусаар дамжуулан нийгэмд суудлын хамгаалах бүсийг тогтмол, зөв хэрэглэх чухал дадал зуршлыг хөгжилтэй сонирхолтой байдлаар сургаж, төлөвшүүлэх зорилготой, зам тээврийн осол гэмтлээс олон хүний амь насыг хамгаалах чухал ач холбогдолтой юм. | 02-12 | 100 |
| 4 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. | | | | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу | 01-01 06 сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Засаг даргын Тамгын газрын тээвэр, шатахуун нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер, Хархорин сумын сум дундын Цагдаагийн хэлтэст тээвэр, шатахуун нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер, ШШГХэлтэс нээлттэй, хаалттай 423 дугаар хорих анги түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер, Орхон сургуулийн үдийн цай нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн хорооны нарийн бичгийн даргаар ажиллав. | | 100 |
| 5 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. | | | | Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд ажлын хэсэгт орж Вангийн овоо багийн 90 өрхийн судалгааг авч нэгтгэн программд оруулсан. Хүнсний аюулгүй байдал, хугацаа дууссан бараа, бүтээгдэхүүн дээр хяналт хийж, электрон тамхины хор хөнөөлийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч худалдан борлуулахгүй байх талаар зөвлөмж гарын авлага тараав. | 02-01<br>03-20 | 100 |
| 6 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. | | | | Төрийн албаны зөвлөлөөс хяналт шалгалт ирэхтэй холбогдуулан төрийн захиргаа, улс төрийн, төрийн үйлчилгээний албан хаагч нарын нийт 43 төрийн албан хаагчийн анкетны бүрдүүлэлт дээр анхаарч ажиллав. | 03 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. | | | | Хөгшин Орхон голын ай сав газрын онцгой хамгаалалтын бүс дэх хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгууллагдаж, албан хаагчттай хамт хог цэвэрлэгээ хийсэн. | 05-08 | 100 |
| 8 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8. | | | | Бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүд"-ийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын албан хаагчид хүүхдийн паркад нөхөн тарилт хийж, 300 гаруй хайлаас тарилаа. | 05-10 | 100 |
| 9 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9. | | | | Өвөрхангай аймгийн хэлний бодлогын зөвлөл, насан туршийн боловсролын төвөөс зохион байгуулсан монгол бичгийн сорилыг ШШГХэлтэс нээлттэй, хаалттай 423-р хорих ангийн 50 гаруй албан хаагчдаас авлаа. | 05-23 | 100 |
| 10 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 10. | | | | Олон улсын хүүхдийн эрхийн өдрөөр унадаг дугуйн уралдаан, байр шагналыг бэлтгэв. Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс "Нар шиг гэрэлтэх жаалууд" баярын үйл ажиллагаанд зохион байгуулалтын ажлын хэсэгт орж ажилласан. | 06-01 | 100 |
| 11 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 11 | | | | Хангай Хайрханы тахилгын хурдан морины ажлын хэсэгт ажиллаж хурдан морины унаач хүүхэд | 06-04 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | давхардсан тоогоор 70 хүүхэд бүртгэсэн. | | |
| 12 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 12 | | | | Өвөрхангай аймгийн Хархорин сумын иргэн Б.Батхаан маань 2025 оны 03-р сарын 06-нд авто осолд орж, нурууны яс хугарч суумгай болсон хүүд Засаг даргын Тамгын газрын хамт олноос 1,015,000 төгрөгийн хандив өргөсөн. | 09-16 | 100 |
| 13 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 13 | | | | Малчдын зөвлөгөөн 2025 арга хэмжээнд ажлын хэсэгт орж ажиллав. | 10-11 | 100 |
| 14 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 14 | | | | 3 дугаар багийн зохион байгуулагч Д.Хишигсүрэнд Засаг даргын Тамгын газрын хамт олноос 950,000 төгрөгийн хандив цуглуулав. | 10 -28 | 100 |
| 15 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 15 | | | | Хэлний бодлогын салбар зөвлөлөөс төрийн байгууллагуудад Монгол бичиг -3 хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллав. "Монгол бахархал" аяны хүрээнд Монгол бичгийн олимпиад амжилттай зохион байгуулагдлаа. Хархорин сумын Хэлний бодлогын зөвлөлөөс санаачлан уламжлалт өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, сурагчдын монгол бичгийн мэдлэг чадварыг дэмжих зорилгоор Монгол бичгийн олимпиадыг амжилттай зохион байгууллаа. | 11-20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 16 | | | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг 43 албан хаагчдаас авч дүнг нэгтгэв. | 11-21 | 100 |
| 17 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 17 | | | | Орхон сургуулийн хичээлийн өргөтгөл 320 хүүхдийн сургуулийн барилгын хүлээж авах комисст орж ажиллав. | 12-02 | 100 |
| 18 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 18 | | | | 2025 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын комисст томилогдон ажиллахаар бэлтгэл ажил хангасан. | 12-07<br>12-10 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН :**

| | | |
|---|---|---|
| НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН | Ж.СОЛОНГО .......................... | 2025 ..12.. ..03.. |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |